



Монгол Улсын Үндэсний аудитын газар

УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны саналаар  
хийсэн аудитын тайлан

## ***Ашгийг хууль бусаар хуваарилжээ***

**Иргэний бүртгэл, мэдээллийн улсын  
төвийн зарим үйл ажиллагаа**



**ҮАГ-1/2007/2-ЭА**

Улаанбаатар хот

2007 оны 5 дугаар сар

# Агуулга

## **Тайланг бэлтгэсэн:**

ҮАГ-ын Нэгдүгээр газрын  
захирал Д.Ганбилэг

Аудитын менежер Ж.Батсайхан

Ахлах аудитор Ц.Гэрэл

Аудитор С.Андруш

Шинжээч Ш.Энхтайван

2007 оны 5 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын  
Веб сайт-аас үзнэ үү:

[www.mnao.pmis.gov.mn](http://www.mnao.pmis.gov.mn)

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах зүйл  
байвал 261885 дугаарын утас,  
323266 дугаарын факсаар  
харилцана уу.

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4 дүгээр байр,  
Бага тойруу-6, Улаанбаатар-46  
Монгол Улс

Ерөнхий зүйл..... 3

1. Аудит хийсэн үндэслэл
2. Аудитын зорилт, хамарсан хүрээ
3. Аудитын арга зүй
4. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн  
талаархи товч танилцуулга

**Бүлэг 1: Төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн  
биелүүлээгүй байна.....6**

- 1.1 Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт
- 1.2 Татвар, хураамжийн ногдуулалт, төлөлт
- 1.3 Ногдол ашгийн хуваарилалт, төлөлт
- 1.4 Төсвөөс олгосон урт хугацаат зээлийн ашиглалт,  
төлөлт

**Бүлэг 2: Үндэсний энгийн гадаад паспортын үнэ  
үндэслэлгүй тогтоогджээ.....12**

**Бүлэг 3: Худалдан авалтыг хууль, тогтоомжийн  
дагуу төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна. ....15**

**Бүлэг 4: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах  
боломж байна.....18**

Дүгнэлт.....19

Зөвлөмж.....19

Товчилсон үгс:

ҮАГ – Үндэсний аудитын газар

УИХ – Улсын Их Хурал

ИБМУТ – Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв

ХЗДХЯ – Хууль зүй, дотоод хэргийн яам

ХБНГУ – Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

## **Ерөнхий зүйл**

### **1. Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **2. Аудитын зорилт, хамарсан хүрээ**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар тогтоосон зарим эрсдэлтэй асуудалд аудит хийж, үр нөлөөг сайжруулах санал зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- ИБМУТ-ийн төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт;
- Гадаад паспорт хэвлэх, олгох үйл ажиллагааны үр ашиг;
- ИБМУТ-ийн 2006 оны худалдан авалт;
- Санхүүгийн дотоод хяналтын үр нөлөө.

Аудитаар ИБМУТ, ХЗДХЯ, “Титан Интернэшнл” ХХК-ийн дэргэдэх үнэт цаасны хэвлэх үйлдвэрийн 2006 оны санхүүгийн болон бусад холбогдох материалыг шалгалаа.

### **3. Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, Төрийн хяналт шалгалтын стандарт, эрсдэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад эрсдэлийн аудитын үндсэн элементүүд болох үнэн зөв байдал, зүй зохис болон санхүүгийн хяналттай холбоотой асуудлыг авч үзлээ.

Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг, аудитын менежер Ж.Батсайхан нар удирдаж, Цэрэг, хууль сахиулах байгууллагын багийн аудитор С.Андруш, шинжээч Ш.Энхтайван нар 2007 оны 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэв.

#### **4. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн талаархи товч танилцуулга**

ИБМУТ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Тус төвийн үндсэн үүрэг зорилго нь Монгол Улсын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, баримт бичиг хүчингүй болгох, иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, иргэний баримтын төв архив, хүн амын автоматжуулсан төв регистрийн мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, иргэний бүртгэлийн ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, иргэд байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж байна.

Тус төв 2006 оныг “Иргэний бүртгэлийн ажилтны ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, хүнд суртлыг арилгах жил” болгон ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Тухайлбал: Засгийн газрын 2005 оны 65 дугаар тогтоолын дагуу “Иргэний бүртгэл, паспорт-хяналтын нэгдсэн сүлжээ” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүлжээнд ашиглагдах бүх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг татан авсан бөгөөд хуваарийн дагуу эхний ээлжинд Хил хамгаалах ерөнхий газрын сүлжээний программ хангамжийг хийж дуусган хилийн шалган нэвтрүүлэх боомтын байцаагч нарт холбогдох сургалт зохион байгуулжээ.


НҮБ-ын Хүн амын сан, ИБМУТ-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу “Иргэний бүртгэл мэдээллийн байгууллагын чадвар, мэдээлэл солилцох чадавхийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Ховд аймгийн 18 сум, Увс аймгийн 11 сум, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн албадыг нийт 31 компьютер, дагалдах хэрэгслээр хангаж, холбогдох сургалтыг зохион байгуулсан байна.

ИБМУТ-ийн даргын 2006 оны 10 дугаар тушаалаар “Монгол Улсын иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөний улсын үзлэг”-ийг 2006 оны 4 дүгээр сарын 10-наас 15-ны өдрүүдэд зохион байгуулж, хаягийн зөрчилтэй 11000 гаруй иргэдийн материалыг шалган, орон нутгаас нийслэлд шилжүүлэггүй оршин суугаа 8290 иргэний судалгааг аймаг, сум, дүүргийн оршин суугаа хаягаар нь ангилан гаргаж зөрчлийг арилгуулсан байна.

ИБМУТ 2006 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийг нийт 1,6 сая төгрөгөөр хэмнэжээ.

Тус төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний бүртгэлийн тухай, Гэр бүлийн тухай, Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хууль, түүнчлэн холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллаж байна.

ХЗДХСайдын 2006 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 192 дугаар тушаалаар Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн орон тооны дээд хязгаарыг 122 байхаар тогтоож, доорхи бүтэц зохион байгуулалтаар ажиллуулахаар болжээ.



## **Бүлэг 1: Төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.**

### **1.1 Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт**


Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хуулиар ИБМУТ-ийн 2006 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 662,5 сая төгрөгөөр баталжээ.

Дээрх төлөвлөгөөг 29,5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч орлогын гүйцэтгэлийг зүйл тус бүрээр төлөвлөгөөтэй харьцуулан үнэлэлт өгөх боломжгүй байна. Энэ нь Сангийн яам, ХЗДХЯ-ны холбогдох албан тушаалтнууд ИБМУТ-ийн 2006 оны батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг орлогын төрөл тус бүрээр гаргаж өгөөгүйтэй холбоотой байна.

ИБМУТ-ийн 2006 оны орлогыг бүтцийн хувьд авч үзвэл дараахь байдалтай байна.

№	Орлогын нэр төрөл	Дүн	Хувь
1	Шинэ паспорт олголт	1461044.7	63.9
2	Паспорт сунгалт	115145.7	5.0
3	Лавлагаанаас	25140.5	1.1
4	Яаралтай үйлчилгээ	236197.5	10.34
5	Үнэт цаасны борлуулалт	441755.4	19.3
6	Үйл ажиллагааны бус орлого	5396.2	0.2
	Дүн	2284680.0	100

### **ИБМУТ-ийн 2006 оны орлогын бүтэц**



## 1.2 Татвар, хураамжийн ногдуулалт, төлөлт

ИБМУТ татвар, хураамж, төрийн өмчийн ногдол ашгийн талаарх тайлан, мэдээг татварын байгууллага болон бусад байгууллагад тогтоосон хугацаанд нь гаргаж, тооцоо нийлж баталгаажуулсан байна.

ИБМУТ зарим төрлийн татвар, хураамж, төрийн өмчийн ногдол ашгийг 2006 онд хэрхэн ногдуулж, улсын төсөвт төлсөн байдлыг дараахь хүснэгтэд нэгтгэн харуулав.

(сая.төгрөгөөр)

№	Татвар, хураамжийн нэр	Эхний үлдэгдэл	2006 онд		Эцсийн үлдэгдэл
			Ногдуулсан	Төсөвт төвлөрүүлсэн	
1	Аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар	55.9	286.8	283.7	59.1
2	Төрийн өмчийн ногдол ашиг	439.7	107.8	45.0	502.7
3	Улсын тэмдэгтийн хураамж	8.2	277.4	279.5	6.1
4	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		6.4	6.4	0.0
5	Хүн амын орлогын албан татвар		13.6	13.6	0.0
	Дүн	503.8	692.0	628.2	567.9

Дээрх хүснэгтээс үзэхэд 4 төрлийн татвар, хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэхээс Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, Хүн амын орлогын албан татварыг бүрэн төвлөрүүлж, Аж ахуйн нэгж, байгууллагын албан татвар, Улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

## 1.3 Ногдол ашгийн хуваарилалт, төлөлт

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 12.4-д үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг агентлагийн тухайн жилийн орлогын хуваарилалт, төлөх дарааллыг тогтоосон байна.

Дээрх заалтад агентлагийн тухайн жилийн орлогоос батлагдсан зардлыг нөхөж, төсөвт төлөх төлбөрийн тооцоо хийсний дараа үлдэх орлогын зохих хэсгийг тухайн агентлагт хөрөнгө оруулалт хийх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар үлдээж, бусдыг улсын төсөвт оруулахаар заасан байна.

Тухайн агентлагийн мэдэлд үлдээх орлогын хувь хэмжээг дээрх хуулийн 4 дүгээр бүлгийн 12.5-д санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрхэлсэн асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн нар хамтран тогтоож байхаар заажээ.



Харин ИБМУТ 2005, 2006 онд төсөвт төвлөрүүлэх ёстой орлогыг бүрэн төвлөрүүлээгүйн гадна зарим албан тушаалтнууд хууль бус шийдвэр гарган, орлогын хуваарилалтыг буруу хийж, төрийн өмчийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан байна.

Тухайлбал ИБМУТ 2006 оны санхүүгийн тайлангаар улсын төсөвт төлөх ёстой дараахь өглөгтэй гарчээ. Үүнд:

№	Татвар, хураамж, ногдол ашгийн өглөгийн төрөл	2006 оны эхний үлдэгдэл	Гүйлгээ		2006 оны эцсийн үлдэгдэл
			Нэмэгдсэн	Хасагдсан	
1	Хүн амын орлогын албан татвар	133,366.0	13,591,625.5	13,580,085.0	144,906.5
2	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар		246,855,800.0	187,788,100.0	59,067,700.0
3	Улсын тэмдэгтийн хураамж		237,411,700.0	231,355,500.0	6,056,200.0
4	Төрийн өмчийн ногдол ашиг		502,668,733.5		502,668,733.5
	Дүн	133,366.0	1,000,527,859.0	432,723,685.0	567,937,540.0

ИБМУТ-ийн 2005 оны цэвэр ашгаас авах төрийн өмчийн ногдол ашиг, улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Сангийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2006 оны 114/57 дугаар хамтарсан тушаалаар дараахь байдлаар хуваарилсан байна.

№	Үзүүлэлт	Дүн (сая.төгрөг)	Нийт орлогын дүнд эзлэх хувь	Тайлбар
1	Нийт орлогын дүн (1.1+1.2)	2284.6	100.0	
1.1	Үйл ажиллагааны орлого	2259.7	98.9	
1.2	Үйл ажиллагааны бус орлого	24.9	1.1	
2	Нийт зардлын дүн (2.1+2.2)	1167.5	51.1	
2.1	Үйл ажиллагааны зардал	1165.3	51.0	
2.2	Үйл ажиллагааны бус зардал	2.2	0.1	
3	Үйл ажиллагааны ашиг (1-2)	1117.1	48.9	
4	Төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн (4.1+4.2)	597.5	26.2	
4.1	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	344.5	15.1	
4.2	Төрийн өмчийн ногдол ашиг	252.9	11.1	Цэвэр ашгийн 30 хувиар тооцсон

5	Үлдэж буй орлого (3-4)	519.7	22.7	
5.1	Улсын төсөвт төвлөрүүлэх (5 x 35%)	181.9	8.0	
5.2	ХЗДХЯ-нд төвлөрүүлэх (5 x 65%)	337.8	14.8	Тухайн агентлагт үлдээх ёстой орлого

Дээрх шийдвэрээс харахад ИБМУТ-ийн мэдэлд үлдэх орлогыг ХЗДХЯ-нд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ХЗДХЯ-нд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 337,8 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2006 оны 81 дүгээр тушаалаар дахин хуваарилж, энэ хөрөнгийн 35 хувь буюу 118,2 сая төгрөгийг ИБМУТ-д, 65 хувь буюу 219,6 сая төгрөгийг тус яамны мэдэлд үлдээж зарцуулсан байна.

ХЗДХЯ энэ хөрөнгийг дараахь байдлаар зарцуулсан байна.

№	Гүйлгээний		Дүн		Тайлбар
	Товч утга	Огноо	Бэлэн мөнгөөр	Бэлэн бусаар	
1	Яамны барилгын засварын зардал	7/20/2006		147,6	
2	Орон сууц худалдан авах, орон сууцны нөхцлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд зориулсан дэмжлэг /ХЗДХЯ-ны зарим ажилтан албан хаагчдад/			50,0	ХЗДХЯ-ны ТНБД-ын 2006 оны 112 дугаар тушаалаар
2.1	ХЗДХЯ-ны мэдээлэл хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Л.Мөнхбаатар	7/20/2006		15,0	
2.2	ХЗДХЯ-ны Хууль зүй, бодлогын газрын ахлах мэргэжилтэн Л.Мөнхцэцэг	8/3/2006		15,0	
2.3	ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ж.Оюунчимэг	8/3/2006		10,0	
2.4	ХЗДХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Д.Гэрэлчулуун	8/3/2006		5,0	
2.5	ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ш.Үнэнтөгс	8/3/2006		5,0	
3	Автомашин худалдаж авахад (Дэд сайд Ш.Сүхбаатарын албан хэрэгцээнд)	7/8/2006		20,0	Эрхэм төр ХХК-д ХЗДХЯ-ны өмнөөс
4	ХЗДХЯ-ны гадна хашаанд зориулж	9/12/2006	2,0		Н.Цэвэлмаа
	Дүн		2,0	217,6	

Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар ИБМУТ-ийн 2005 оны ашгийн хуваарилалтын хувь хэмжээг тогтоохдоо тус төвийн мэдэлд үлдээж зарцуулах ёстой хөрөнгийг ХЗДХЯ-нд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.4 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд ХЗДХЯ-д төвлөрүүлсэн 219,6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2006 оны 195 дугаар тушаалаар “Хууль зүйн алба байгуулагдсаны 85 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний сан”-д төвлөрүүлсэн 50,000,000 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй юм.

ИБМУТ 2006 онд төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашиг, татвар, хураамжийн 567,937.54 мянган төгрөгийн өглөгтэй, түүнийг төлөх эх үүсвэргүй байгаа нь тус төвийн мөнгөн хөрөнгийг яаманд үндэслэлгүй татан төвлөрүүлж, зарцуулсантай холбоотой байна.

#### **1.4 Төсвөөс олгосон урт хугацаат зээлийн ашиглалт, төлөлт**

ИБМУТ 2006 онд үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эргэлтийн хөрөнгө бий болгох зорилгоор улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлтэй дараахь зээлийг авсан байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2005 оны 168 дугаар тушаалаар DSL 03/22 дугаар “Төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах гэрээ”-ний дагуу 848,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн зээлийг 2 жилийн хугацаатай, жилийн 3,89 хувийн хүүтэйгээр, “Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ” төслийг санхүүжүүлэх эх үүсвэрт зориулан 507,948 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн зээлийг 2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр, 340,052 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн зээлийг 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдөр авсан байна.
2. Засгийн газрын 2006 оны 84 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2006 оны 137 дугаар тушаалаар төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах DSL 06/01 дугаартай гэрээ байгуулж, Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт хэвлүүлэх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт зориулан 229,000 еврогийн зээлийг 1 жил 3 сарын хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэйгээр, 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдөр авсан байна.

Зээл авах өдрийн Монголбанкны ам.долларын албан ханш 1200 төгрөг, еврогийн албан ханш 1473,8 төгрөг байсан ба 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доллар 1165 төгрөг, евро 1509,3 төгрөг байжээ.

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл, эргэн төлөлтийг харуулбал:

№	Үзүүлэлт	(Доллар)-ын зээл (доллараар)	(Евро)-гийн зээл (Еврогоор)
1	Зээлийн үндсэн төлбөр	253,974.00	91,600.20
2	2006 онд	Үндсэн өрийн төлбөр	76,565.58
3		2006 онд төлбөл зохих хүү /графикаар/	2,368.86
4		Хүүгийн төлбөр /ашиглалтаар/	2,514.54
5		2006.12.31-нээрх зээлийн үлдэгдэл	152,539.13
		168,955.99	

Дээрх зээлийн гэрээний хавсралт болох зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2006 оны 12 дугаар сард 21,164.5 ам.доллар, 15,266.2 евро улсын төсөвт буцааж төлөх ёстой байсан боловч төлөөгүй байна.

2006 онд 1,595,028.72 төгрөгийн ханшийн зөрүүний алдагдалтай, 680,778.45 төгрөгийн ханшийн зөрүүний ашигтай, цэвэр дүнгээрээ 914,250.27 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## **Бүлэг 2: Үндэсний энгийн гадаад паспортын үнэ үндэслэлгүй тогтоогджээ.**

Монгол Улсын Үндэсний энгийн гадаад паспортын жилийн хэрэглээ 110000 орчим байдаг. 2006 онд 200000 ширхэгийг худалдан авч, 12 дугаар сарын 31-ний өдрөөр үлдэгдэл 133000 ширхэг байгаа нь 2007 оны нөөц бүрэн хангагдсан байна.

2006 онд худалдан авсан гадаад паспортын төлбөрийн 229000 еврог Төрийн сангийн зээлээр, үлдэх 229000 еврог өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

ИБМУТ нь ХБНГУ-ын “Гизике-Дивриент” компанитай 2005 онд байгуулсан 1700346/1DV022/05 дугаар гэрээний дагуу 1 ширхэг гадаад паспортыг 2,29 еврогоор хэвлүүлж байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийг уг компанийн Монгол Улс дахь итгэмжлэгдсэн төлөөлөгч болох “Титан Интернэшнл” ХХК-тай 2002 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу 4,52 ам.доллараар хийлгэж байжээ.

Гэтэл паспортын бичилтэд шинэ технологи нэвтрүүлж байгаатай холбогдуулан “Титан Интернэшнл” ХХК-тай 1DV022/05 дугаар гэрээг дахин байгуулж, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Гадаад хэргийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 465/72/205 дугаар хамтарсан тушаалаар дээрх үнийг өөрчлөн 6 ам.доллар болгосон байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийн өртгийг зардлын зүйл тус бүрээр дараахь хүснэгтэд харуулав.


№	Үзүүлэлт	Ам.доллараар	Төгрөгөөр	Нийт дүнд эзлэх хувь (ам.доллар)
1	Байрны түрээс	0.40	466.00	6.67
2	Оффисын тавилга, хэрэгсэл худалдан авах	0.16	186.40	2.67
3	Тоног төхөөрөмж /татвар, гаалийн татварыг оруулсан дүн/	0.93	1083.45	15.50
4	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ /татвар, гаалийн татвар оруулсан дүн/	0.16	186.40	2.67
5	Сэлбэг хэрэгслийн зардал /татвар, гаалийн татвар оруулсан дүн/	0.29	337.85	4.83
6	Программын лицензийн төлбөр	0.15	174.75	2.50
7	Бусад төрлийн татвар, хураамж	0.05	58.25	0.83
8	Тоног төхөөрөмжийг угсрах суурилуулах зардал	0.19	221.35	3.17
9	Чанарын баталгаа, засвар үйлчилгээ	0.35	407.75	5.83
10	Ажиллагсдын цалин, НДШ	0.93	1083.45	15.50
11	Цахилгаан, дулаан, ус ашиглалтын төлбөр	0.33	384.45	5.50
12	Харилцаа холбоо ба хамгаалалтын зардал	0.11	128.15	1.83

13	Паспорт хүргэлт, хүлээн авах тээвэрлэлтийн зардал	0.28	326.20	4.67
14	Зураг хэвлэлт, мэдээлэл бичилт болон 3-р хуудасны мэдээлэл оруулах зардал	0.98	1141.70	16.33
15	Хэвлэлтийн тээвэрлэлт	0.06	69.90	1.00
16	Программ ба тоног төхөөрөмж ИНФАКО технологи	0.44	512.60	7.33
17	Бусад зардал /бичиг хэргийн зардал гэх мэт/	0.05	58.25	0.83
18	Санхүүгийн зардал /зээлийн хүү/	0.14	0.14	2.33
	Нийт	6.00	6827.04	100.00

Дээрх хүснэгтээс харахад нэг ширхэг үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийн өртөг үндэслэл муутай тогтоогджээ.

Тухайлбал, оффисын тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг нэг удаагийн шинжтэй зардлыг өртөгт шингээсний гадна өдөрт дунджаар 378 ширхэг паспортанд бичилт хийлгэдэг гэж үзвэл нэг өдрийн тээврийн зардал 105,84 ам.доллар буюу 123,303.0 /378\*0,28\*1165/ төгрөг болж байна.

ИБМУТ-өөс “Титан Интернэшнл” ХХК хүртэл 6 км байдаг бөгөөд өдөрт 2 удаа тээвэрлэлт хийдэг. Эндээс үзэхэд өдөрт нийт 24 км газар 378 ширхэг гадаад паспорт тээвэрлэсний хөлсөнд дээрх төлбөрийг паспорт тутмын өртөгт шингээн авч байна.



Иймд Үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийн өртгийг хянаж үзэх нь зүйтэй байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийн нэгж өртөг өндөр байгаа нь паспортын үнэ нэмэгдэхэд нөлөөлжээ.

Үндэсний энгийн гадаад паспортын нийт өртгийг дараахь хүснэгтээр үзүүлэв.

Үндэсний энгийн гадаад паспорт жилээр	Үнэт цаасны үнэ	Улсын тэмдэгтийн хураамж	Үйлчилгээний үнэ	Гадаад паспортын бичилт, бүртгэлийн үнэ	Бусад зардал	Олгох үнэ
1 жил	5000	2500	2000	6 ам.долларыг Монголбанкны тухайн өдрийн ханшаар тооцож нэмдэг	1500	18000
2 жил	5000	2500	4000		1500	20000
3 жил	5000	2500	6000		1500	22000
4 жил	5000	2500	8000		1500	24000
5 жил	5000	2500	10000		1500	26000

Сангийн сайд, Гадаад хэргийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2006 оны 455/72/205 дугаар тушаал, ИБМУТ-ийн даргын 2006 оны 92 дугаар тушаалаар 2006 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 1 ширхэг паспортын бичилт, бүртгэлийн үнийг 6 ам.доллараар тогтоожээ.

Гэтэл ИБМУТ 2006 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 1 ширхэг паспортын бичилт, бүртгэлийн үнийг 6,00 ам.доллараар тооцон төлж, нийт 17461 ширхэг паспортын үнэнд 30,191,650,72 төгрөгийг илүү төлсөн тул “Титан интернэшнл” ХХК-иар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэв.

### **Бүлэг 3: Худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.**

Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Бараа ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”-ын 2 дугаар бүлэгт заасны дагуу захиалагч байгууллага тухайн жилийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх график, төлөвлөгөө гаргаж, түүнд тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэр, төрөл тус бүрээр тендерийн хороо байгуулах, тендерийн бичиг баримт бэлтгэж, батлуулах, тендерийн урилгыг зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх зэрэг ажлуудыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлэхийг тодорхойлох ёстой.

Худалдан авах ажиллагааны явцын тайланд худалдан авах ажиллагааны хөрөнгийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны сонгосон журам, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх хугацаа, тэдгээрийн санхүүжилт зэрэг ажлыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлсэн байдлыг тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тодорхойлсон байх ёстой.

ИБМУТ 2006 онд худалдан авах бараа, ажлын төслийг баталж, холбогдох шийдвэр гарсны дараа уг төлөвлөгөөтэй уялдуулан худалдан авах ажиллагааны график, төлөвлөгөө, явцын тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ажлын явц, цаг хугацаа, хүн хүчний асуудлыг нарийн төлөвлөхгүй байгаагаас тендерийг хуульд заасан хугацаанд зарлах боломжгүй болж, тендер шалгаруулалт зарлалгүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хууль зөрчих, тендерт оролцогчдын тендерт оролцох боломжийг тэр хэмжээгээр хязгаарлах, захиалагч хэрэглэгчдэд хүргэх бараа, ажил, үйлчилгээг цаг хугацаанд нь өгч чадахгүй байх зэрэг нөхцөл бүрдэж байна.

Энэ байдлаас болж ИБМУТ-ийн 2006 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан төсөв, гүйцэтгэл зэрэг мэдээллийг худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр гаргаж авахад цаг хугацаа нилээд зарцууллаа.

ИБМУТ 2006 онд нийт 1,330.4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсны дотор 147,2 сая төгрөгийн бараа, 1,183.2 сая төгрөгийн ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

Дээрх худалдан авалтыг Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн дагуу ангилан харуулбал дараахь байдалтай байна.



№	Хэрэглэх арга	Босго үнэ (Төгрөгөөр)			Босго үнээс давсан худалдан авалтын		Тайлбар
		Бараа	Ажил	Үйлчилгээ	Тоо	Үнийн дүн	
1	Нээлттэй тендер	30 саяас дээш	50 саяас дээш	30 саяас дээш	5	1,073,439,879.50	Тендер зарлаагүй
2	Харьцуулалтын арга	30 сая	50 сая	30 сая	40	230,120,645.00	Үнийн харьцуулалт хийгээгүй
3	Шууд худалдан авалт	1 сая	-	1 сая	139	26,833,926.00	

Энэхүү мэдээлэлд тусгагдсан худалдан авалтыг гүйлгээ тус бүрээр нэгтгэж, ажлын баримтад хавсаргалаа.

Тухайлбал, 2006 онд ХБНГУ-ын “Гизике-Дивриент” компанитай 2005 онд байгуулсан 1700346/1DV022/05 дугаар гэрээний дагуу 826,2 сая төгрөгийн гадаад паспорт, “Үндэсний үнэт цаас” ХХК-тай байгуулсан SP-2619 дүгээр гэрээний дагуу 111,9 сая төгрөгийн иргэний үнэмлэхийн суурийг тус тус шууд гэрээний дагуу хэвлүүлсэн байна.

ИБМУТ хангамжийн материал худалдан авахдаа үнийн харьцуулалтын арга ашиглаж худалдан авалт хийдэг гэх боловч холбогдох баримт материал алга байна.

Тус төв ижил төрлийн зарим бараа, ажлын нийт төсөвт өртгийг хэд хэд хувааж, төсөвт өртгийг бууруулсан байна. Зарим төрлийн маягт хэвлүүлэх, паспортын хавтас худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгосон байдлыг гүйцэтгэгч тус бүрээр дараахь хүснэгтэд харуулав.

№	Бараа бүтээгдэхүүний				Хэвлүүлсэн	
	Нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Дүн (Төгрөг)	Огноо	Байгууллагын нэр
1	Төрсний гэрчилгээ	40,000	260	10,400,000		"ҮҮЦ" ХХК
		60,000	232	13,938,000		"Мөнхийн үсэг" ХХК
2	Гэрлэсний гэрчилгээ	40,000	260	10,400,000		"ҮҮЦ" ХХК
		33,000	232	7,665,900		"Мөнхийн үсэг" ХХК
3	ХААТР 24 маягт	10,500	39	409,500		"Мөнхийн үсэг" ХХК
		30,000	40	1,200,000		"ТВОД" ХХК
		20,000	39	780,000		"Уран гар" ХХК
4	Паспортын хавтас	55,000	800	44,000,000		"Дөрвөн ачлал" ХХК

	45,000	800	36,000,000	"Батбуянт фаянэнс" ХХК
	6,000	800	4,800,000	"Дэнс трейд" ХХК
	6,000	800	4,800,000	"Зоос банк"
	5,000	800	4,000,000	"Инвест кредит" ББСБ
	10,000	800	8,000,000	"НТМ" ХХК
	10,000	800	8,000,000	С.Самбуу
Дүн			154,393,400	

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчиж байна.

#### **Бүлэг 4: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах боломж байна.**

ИБМУТ-ийн Санхүүгийн тасаг нь ажлын байрны тодорхойлолт болон байгууллагын зорилго чиглэлтэй уялдуулан 2005 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд Ерөнхий нягтлан бодогч 1, нягтлан бодогч 1, туслах нягтлан бодогч 1, нярав 2 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээрх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмууд нь 2002 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Сангийн сайдын 2000 оны 116 дугаар тушаал, 1999 оны 215 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын дансны үлгэрчилсэн заавар болон Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачилал, санхүүгийн тайлангийн маягт зэрэг хууль, тогтоомжуудад үндэслэн бэлтгэгджээ.

Энэхүү бодлого журмын хүрээнд дараахь хавсралт журам зааврууд мөрдөгдөх ёстой. Үүнд:

- Төлбөрийг хянах журам
- Хүүгийн тооцоолол ба төлбөрийн журам
- Хөнгөлөлт, хямдралыг бүртгэх журам
- Буцаалтыг батлах болон олгох журам
- Дараа тооцоогоор ажил, үйлчилгээ, бараа борлуулах журам
- Найдваргүй авлагын нөөц байгуулах, төлүүлэх шат дараалсан арга хэмжээ авах тухай журам
- Сэлбэг шатахууны урьдчилгааны тооцооны журам
- Ажиллагсдад зээл, урьдчилгаа олгох, төлүүлэх журам

Санхүүгийн тасгийн мөрдөж байгаа НББ-ийн дээрх бодлого, журам нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-ын дагуу ИБМУТ-ийн даргын тушаалаар батлагдаагүй байна.

Дээрх бодлогод заасан зарим дэд журмуудыг боловсруулж, батлаагүй байна. Бодлогын хүрээнд боловсруулсан журмууд асуудлыг бүрэн зохицуулахад учир дутагдалтай байна.

Энэ нь санхүүгийн дотоод хяналт сулрах, найдваргүй авлага бий болох, эргэлтийн хөрөнгө үр дүнгүй байрших, улмаар илүү зардал гарах зэрэг эрсдэлийг агуулдаг.

Тухайлбал, 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаархи 19.5 сая төгрөгийн найдваргүй авлагад тухайн байгууллагад хамааралгүй 2 хүнд олгосон 2,317.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараахь **дүгнэлт** хийж байна. Үүнд:

Төсвийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй бөгөөд улсын төсөвт төлөх ногдол ашгийг төлөлгүй 567,9 сая төгрөгийн өр үүсгэсэн байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлийн өртөг үндэслэлгүй тогтоогдсон нь энгийн гадаад паспортын үнэ нэмэгдэх шалтгаан болжээ.

Худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмуудыг боловсронгуй болгох замаар санхүүгийн хяналтыг илүү сайжруулах боломж байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад **зөвлөмж** болгож байна.

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт:

1. Үйл ажиллагааныхаа орлогоор санхүүждэг агентлагын тухайн жилийн орлогын хуваарилалтыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.4-д заасан зориулалт, дарааллын дагуу хийх.
2. Тайлант хугацааны цэвэр ашгаас төсөвт төлөх тооцоо хийгээгүй байхад их хэмжээний мөнгийг ХЗДХЯ-нд үндэслэлгүйгээр төвлөрүүлж, түүгээрээ зарцуулахыг таслан зогсоох
3. Улсын Их Хурлаас баталсан харьяа агентлагийн тухайн жилийн төсвийг орлого, зарлагын зүйл тус бүрээр нарийвчлан баталгаажуулж байх.

2. Иргэний бүртгэл мэдээллийн төвийн дарга А.Энхжавт:

1. Улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийг бүрэн төвлөрүүлж дууссаны дараа хөрөнгө оруулалт болон нийгмийн асуудалд хөрөнгө зарцуулах асуудлыг шийдэж байх.
2. Энгийн гадаад паспортын бичилт, бүртгэлжүүлэлтийн өртгийг бууруулах талаар гүйцэтгэгч байгууллагатай дахин зөвшилцөж, шаардлагатай бол өөр гүйцэтгэгчийг сонгон шалгалруулах арга хэмжээ авах.

3. Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид заасны дагуу тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх.
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдүүлэх.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

### ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН ТӨВ

2106206 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цагдаагийн гудамж, Утас: 26-47-97, Факс: (976-11) 35-02-58  
E-mail: IBMUT@yahoo.com, enjav@yahoo.com,  
http://cro.pmis.gov.mn


2007.05.25 № 1/1874  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тус төвийн 2006 оны санхүүгийн үйл ажиллагаанд  
Үндэсний аудитын газраас хийсэн эрсдлийн аудитын  
тайлантай санал нэг байна.



ДАРГА

 А.ЭНХЖАВ

## ТУШААЛ

### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг УИХ-ын Хууль зүйн Байнгийн хороо, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, ИБМУТ-ийн дарга А.Энхжав нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2007 оны 10 сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга А.Энхжав нарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын  
2007 оны ... дугаар тушаалын  
хавсралт

**Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд хийсэн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт**

	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Актын дугаар	Төлбөрийн дүн	Үүнээс	
	Нэр	Албан тушаал				Төсөвт	Байгууллагад
1	А.Энхжав	ИБМУТ-ийн дарга	Паспортын бичилтийн үнийн зөрүү	1/03	30191650.00	30191650.00	
	Б.Өэлүн-Үжин	Ерөнхий нягтлан бодогч					
2	А.Энхжав	ИБМУТ-ийн дарга	Ашгийн хууль бус хуваарилалтын төлбөр	1/04	269600000,00	269600000,00	
	Б.Өэлүн-Үжин	Ерөнхий нягтлан бодогч					
<b>Нийт дүн</b>					<b>299791650,00</b>	<b>299791650,00</b>	